

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Булган аймгийн Эрүүл мэндийн газар

2025 оны III улирал

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын тогтоол							
1	1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3.	"Стандарт хэмжил зүйн газрын "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS 6395:2022 баримтлан А4, А5 албан бичиг, захирамжлалын баримт бичгийн хэвлэмэл хуудасны бүрдлийг кирилл, монгол бичгээр хэвлүүлэх хүсэлтээ хүргүүлсэн. Албан хаагчдын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд монгол бичгийн уншиж, бичих чадвараа сайжруулах талаар заалт тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт албан хаагчдын компьютерт монгол бичгийн үсгийн фонт суулган, цахим бичвэрийн сургалтын гарын авлагыг танилцуулсан. Монгол бичгийн хичээлийг цувралаар цахим хаягт байршуулсан. Байгууллагын гадна хаяг, албан хаагчдын өрөөний хаяг, нэр, хувийн хэргийн хаягийг монгол бичгээр үйлдсэн.	Хэрэгжсэн	100%	

			төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
2	2	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам)	2025 оны орон нутгийн төсвийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын Б блокийн хэсэг 350.0 сая төгрөг, Хангал сумын ЭМТ-ийн барилгын засвар 305.0 сая төгрөг, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засвар 400.0 сая төгрөг, Сайхан сумын ЭМТ-ийн 2 барилгыг ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажил 68.0 сая төгрөг, Могод сумын ЭМТ-ийн моорог, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажил 104.0 сая төгрөг, Булган сумын “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн дулаан, цэвэр усны шугамыг төвлөрсөн системд холбох ажил 300.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн барилга 2 барилгад лифт угсарч суурилуулах ажил 400.0 сая төгрөгийн барилгын засварын ажлууд тус тус батлагдсан. Могод сумын ЭМТ-	Хэрэгжсэн	100%	

				ийн моорог, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажил 100 хувь дууссан. Нэгдсэн эмнэлгийн 2 барилгад лифт суурилуулах ажлын гүйцэтгэгчээр “Оакс инженеринг” ХХК шалгарч угсралтын ажил 90 хувьтай явагдаж байна. Хангал сумын ЭМТ-ийн барилгын засварын ажил, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлууд бүрэн хийгдэж дууссан. “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн барилгыг төвлөрсөн инженерийн шугамд холбох ажил 60%-тай явагдаж байна. Сайхан сумын ЭМТ-ийн ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажил хийгдэж дууссан. Сэлэнгэ сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгын ажлын саналыг 2026 оны төсөвт тусгахаар pimis.publicinvestment.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентгений хэсэг, яаралтай тусламж 103, тасгийн барилгын засварын ажил хийгдэж дууссан.			
3	3	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга	Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг төрийн болон ТББ, иргэдийн дунд зохион байгуулан, уулзалт, ярилцлага хэлэлцүүлэгийг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд- 19 нэрэмжит сарын аян-8 удаа , иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 53 удаагийн тахимийн сургалтнд 7882 иргэдийг хамруулж, сурталчилгаанд давхардсан тоогоор 17624 иргэнийг хамруусан. Сайхан Монгол тв-тэй хамтран “Анхдагч зөвлөгөө танд эрүүл мэндийн боловсролд зориулсан ярилцлага-6, контент-3,	Хэрэгжсэн	100%	

			хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	цахим сурталчилгааг-10 удаа, ажил мэргэжил сурталчилсан 5 удаагийн нэвтрүүлгийг бэлтгэн цахм хуудсаар иргэд олон нийтэд хүрэн ажилсан. Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.go.mn болон Булган Эрүүл мэндийн газар нүүр хуудсаар мэдээллийг хүргэн цахим хуудсаар мэдээ, мэдээллийг үнэн зөв хүргэх зорилгоор ЭМБ-д давхардсан тоогоор 252 мэдээллийг цахим хуудсан байршуулж, 47684 хүн цахим хуудсанд хандсан.			
4	4	“Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322	2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Эрүүл шүд арга хэмжээг аймгийн хэмжээнд эрчимжүүлэн 2024 оноос ЕБС-ийн бага ангийн суралцагсад үдийн цайны дараа шүд угаах цагийг бий болгож, шүдээ угааж эхэлсэн. “Шүд угаах цаг” зохион байгуулах зөвлөмж бичлэгийг Сайхан Монгол тв-тэй хамтран бэлтгэж цахим сургалтыг ЭМБ-ын дарга, нийгмийн ажилтан, ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, эмч нарт зохион байгуулсан. ЕБС-ын үдийн цай хөтөлбөрийн дараа шүд угаах цагийг 55 ангид бий болгосон. 24/3-Шүдээ зөв угаа-2025 аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 6470 хүүхдийг хамруулж, 3449 хүүхдэд нэмэлт эрдэсжүүлэлт хийсэн. Аяны турш амны хөндийн эрүүл мэндийн талаарх зөвлөмжит видео контент 3, зөвлөмж мэдээлэл 5 төрлийг бэлтгэн Эрүүл мэндийн газар болон бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар мэдээлж, нийгмийн сүлжээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд түгээсэн. Мөн аймгийн шүдний эмч мэргэжилтний холбооноос “Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох”	Хэрэгжсэн	100%	

				мэдээллийг бэлтгэн аймгийн хэмжээнд нэгдсэн нэг сургалтын гарын авлагаар сургалт мэдээллийг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 35 удаагийн сургалт зохион багуулж, 3100 гаруй иргэдийг хамруулсан. 3-р улиралын байдлаар "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд 18 хүртэлх насны хүүхдийн шүд, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, үзлэг, эмчилгээ, зөвлөгөө өгөхөөр Япон-Азийн эрүүл мэндийг дэмжих байгууллага, "Ц.Бадрал" сан, АШУИС-ийн Нүүр ам судлалын сургууль, Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетын эмч нар хамтран үзлэг зохион байгуулж, 170 хүүхдэд шүдний үзлэг, зөвлөгөө, эмчилгээг хийгдсэн. үүнээс тусгай хэрэгүүдэд 4 хүүхдэд шүдний тусламж үйлчилгээ үзүүлсэн.			
5	5	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1."Журам батлах тухай" Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид	"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын дагуу улсын төсвөөс 31 төрийн албан хаагч, орон нутгийн төсвөөс 20 төрийн захиргааны албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгож байна.	Хэрэгжсэн	100%	

			орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)				
6	6	Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83	3.. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.)	Засгийн газрын 2024 оны 83 тогтоолоор 2024 онд ЭМС-ийн төрийн захиргааны 11 албан хаагчид нийт 78.2 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. 2025 оны төсөвт 1 төрийн албан хаагчийн 7.3 сая төгрөгийн мөнгөн урамшуулалыг олгохоор тооцон төсөвт батлуулсан	Хэрэгжсэн	100%	
7	7	Яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-02-05 Дугаар 2025_67	3. 3.Орон нутагт яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн “112” дугаарлалтаар хүлээн авах үйл ажиллагааг Төле камерын хяналтын дэд төвүүдийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	.	Хамааралгүй		
8	8	Хойд бүсийн	1.3.4.. 1.3.4.Булган аймгийн	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой эмнэлгийн	Хэрэгжсэн	100%	

		хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-04-28 Дугаар 2025_204	Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг судалж, шийдвэрлүүлэхийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Булган аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир нарт;	барилгын холболтын зураг, төсвийн дагуу барилгын ажлын саналыг 2026 оны улсын төсөвт тусгуулахаар холбогдох баримт бичгийн хамт ЭМЯ-нд хүргүүлсэн.			
9	9	Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай 2025-06-04 Дугаар 2025_279	1. 1.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.	ЭМГ-ын даргын тушаалаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудад чиглэл хүргүүлсэн. Баяр амралтын өдрөөр амарсан өдрүүдийг 8 9 10 саруудад нөхөж ажиллах хуваарийг хийн ажиллаж байна.	Хэрэгжсэн	100%	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
10	10	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл	ХХ.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга , нягтлан бодогч нарын тоон гарын үсгийн хугацаа дууссан байсаныг анхааруулан сунгалтыг хийлгэсэн. Байгууллагууд тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн байна.	Хэрэгжсэн	100%	

		2022-05-11 Дугаар 2022_28	сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.				
11	11	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл	"Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг аймгийн НЭ-ийн дэмжих төвөөр 966 иргэн, явуулын баг буюу нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоонд 1904 иргэн, нийт 2906 иргэнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулсан. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих иргэдийн 48,5%-ийг хамруулж, өмнөх оныхоос 4.4%-иар өссөн байна. Сумдын	Хэрэгжсэн	100%	

			ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	ЭМТ-үүд элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд 2764 хүний хамруулан, В вирус илрээгүй иргэдийг В гепатитийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын 1, 2, 3-р тунд 2141 хүн тун вакцин хэрэглэсэн байна Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/04 дугаар тушаал, ЭМС, БС-ын хамтарсан 2024 оны А/415, А/151 дугаар тушаалаар ЕБС-ын 6 настуудыг нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2025 оны А/262 тоот тушаалаар үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг батлуулан аймгийн хэмжээнд хамрагдвал зохих 1057 хүүхдийг эрт илрүүлэг үзлэгт шуурхай хамруулах ажлыг гүйцэтгэж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нүдний анхан шатны үзлэгийн хамрагдалт 98,2%, шүдний үзлэгийн хамрагдалт 95%, зүрхний үзлэгийн хамрагдалт 96,2%-тай байна. "			
12	12	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй	2025 оны 09 дугаар сарын байдлаар ERP, Able, Төрийн цахим шуудангаар нийт ирсэн бичиг 691, үүнээс цаасаар 136, цахимаар 555, “ABLE” программд бүртгэгдсэн 436, үүнээс хариутай 338, шийдвэрлэсэн 208, хяналтад байгаа 36, хариугүй 109 байна. Явуулсан бичиг нийт: 576 үүнээс цахимаар 433, цаасаар 143 бичиг явуулсан байна. Байгууллагад үүсэж байгаа баримт	Хэрэгжсэн	100%	

			холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	бичгийн боловсруулалтад хяналт тавьж баримт бичгийн стандартыг баримтлан ажиллаж байна. Баримт бичгийг шийдвэрлэхдээ бүрдэл болсны дараа тамга, тэмдэг дарж, дугаар өгөн, холбогдох газруудад цаасаар болон цахимаар хүргэж байна.			
13	13	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	Хамааралгүй	Хэрэгжсэн	100%	
14	14	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11	XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо,	Аймгийн хэмжээнд 1 ходоодны уян дуран хэвийн ажиллаж байгаа бөгөөд 2025 оны эхний хагас жилд улаан хоолой ходоодны уян дурангийн	Хэрэгжсэн	100%	

		дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	оношилгоонд 693 иргэнийг хамруулсан. Үүнээс 23 тохиолдлыг дээд шатлалд онош тодруулахаар илгээсэн.			
15	15	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-02-26 Дугаар 2025_10	10.19.4.2. Холбогдох хууль тогтоомжоор өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг богино хугацаанд шуурхай зохион байгуулан бүрэн хангахад анхаарч, эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Эрүүл мэндийн яам болон аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг 7, 14 хоног тутам гарган, эрүүл мэндийн салбарын хэрэгжилтийг холбогдох байгууллагад тайлагнан ажиллаж байна.	Хэрэгжсэн	100%	

16	16	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-23 Дугаар 2025_19	19.24.5.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Улаанбурхан өвчнөөс сэргийлэх, тандалт судалгааг аймгийн НЭ-ийн түргэн тусламж, хүлээн авах тасаг, сумын өрхийн ЭМТ-үүдийн амбулатори, хэвтэн эмчлүүлэгч 3230 хүний дунд зохион байгуулж, эмчийн зөвлөгөө заавар өгч ажилласан. Улаанбурхан өвчний 9 тохиолдол бүртгэгдэж, ойрын хавьтал болсон 96 хүнд тандалт судалгааг хийж, нөхөн дархлаажуулалтад 48 хүнийг хамруулсан. аймгийн хэмжээний ЭМБ-уудад улаанбурхан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, нөхөн дархлаажуулах, эргэмжээр программд шивэлт хийх , өвчлөлийг эрт илрүүлэх, оношлох, сорьц тээвэрлэх, эмчлэх сургалтыг цахимаар 5 удаа, танхимаар 2 удаа зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг 4 удаа албан бичгээр ЭМБ-уудад хүргүүлэн ажилласан.	Хэрэгжсэн	100%	
17	17	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-04 Дугаар 2025_26	26.27.6.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх, үндэсний товллын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагад дэмжлэг үзүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Улаанбурхан өвчнөөс сэргийлэх УГУ-эсрэг вакцинд 09 сартайгаас 15 насны 502 хүүхдийг нөхөн дархлаажуулж, 1836 хүүхдийг анхан шатны бичиг баримтыг үндэслэн эргэмжээр программд шивэлт хийлээ. Улаанбурхан өвчний эсрэг вакцинаар 2024 оны 10-12 сард төрсөн, 2025 оны 01-03 сард төрсөн 6-8 сартай 126 хүүхдийн 68.2%-ийг дархлаажуулж, халдвараас сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. Заавал хийх дархлаажуулалтад хамралт 2025 оны эхний 8 сарын байдлаар 1-р тунгийн хамралт 97,9%, 2-р тунгийн хамралт 98,9 % байна.	Хэрэгжсэн	100%	

18	18	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-08-20 Дугаар 2025_13	12.3.2.4.. дотоод орчны агаарын чанарын стандартыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан батлуулж, агаарын бохирдлын өндөр эрсдэлтэй бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг тогтмол хянах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Стандарт, хэмжил зүйн газар (С.Батбаатар), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс гаргахыг холбогдох Засаг дарга нарт тус тус;	Хамааралгүй	Хэрэгжсэн	100%	
----	----	--	--	-------------	-----------	------	--

ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ: 18 заалт 100 % хэрэгжилттэй

Мэдээлэл хариуцагч: Мэргэжилтэн Б.Гантулга

Имэйл хаяг: b.gantulga@bu.moh.gov.mn

Утас: 99442404